



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/362

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Шинэ төгс шийдэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Жишиг гудамж тохижуулах /Жаргалант сум, Бугат баг/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Нямтулга - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Гишүүд:

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

З.Өмиртай - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Б.Түмэндэлгэр - Жаргалант сумын Бугат багийн Засаг дарга

Д.Цогтхүү - Стандарт хэмжилзүйн хэлтсийн байцаагч

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Д.Батсайхан - Барилгын зураг төслийн “Алтайн сүрлэг цамхаг” ХХК-ий захирал

С.Батдорж - Аймгийн архивын тасгийн дарга

Ш.Дамдинсүрэн - “Шинэ төгс шийдэл” ХХК-ий захирал

Нарийн бичгийн дарга:

Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. “Шинэ төгс шийдэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Нямтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ